



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар-919

Улаанбаатар хот

### ┌ Үл хөдлөх эд хөрөнгө нээлттэй дуудлага ┐ худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хавсралтад заасан амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын доод үнийг 42,000,000.00 (дөчин хоёр сая) төгрөгөөр тогтоосугай.

3.Дуудлага худалдаа зохион байгуулахтай холбогдон гарсан зардал (үнэлгээний ажлын хөлс 1,300,000.00 /нэг сая гурван зуун мянган/ төгрөг, хэвлэл, мэдээллийг хэрэгслээр нийтэд зарлах зар, нэгж талбарын хил, заагийн газарт бэхэлсэн эргэлтийн цэг, кадастрын цэг баталгаажуулалтын үнэ 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөг) нийт 1,900,000.00 (нэг сая есөн зуун мянган) төгрөгийг дуудлага худалдааны доод үнэ дээр нэмж тооцсугай.

4.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын нээлттэй дуудлагын худалдааны дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар, үнэ хаялцах доод хязгаарыг 200,000.00 (хоёр зуун мянган) төгрөгөөр, дээд хязгаарыг дэнчингийн хэмжээгээр тус тус тогтоосугай.

5.Нээлттэй дуудлагын худалдааны ялагчтай байгуулах Худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

6.Дуудлагын худалдааны орлогоос тогтоолын 3-т заасан зардлыг хасаж тооцон Улсын төсөвт төвлөрүүлсүгэй.

7.Дуудлагын худалдааны орлогоос үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлын хөлс, нэгж талбарын хил, заагийн газарт бэхэлсэн эргэлтийн цэг, кадастрын цэг баталгаажуулалтын үнийг “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

8.Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

9.Шинэ өмчлөгчид шилжих хүртэл хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан, Төрийн өмчийн төлөөлөгч нарт тус тус үүрэг болгосугай.

10.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2023 оны 06 дугаар сарын 22-ны  
өдрийн 319 дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР  
ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн байршил	Хэмжээ	Балансын нийт үнэ /төгрөг/	Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах доод үнэ /төгрөг/
1	Амины орон сууцны зориулалт бүхий дуусаагүй барилга (Газар эзэмших эрхийн гэрчилгээ 500м <sup>2</sup> )	Дархан-Уул аймаг, Дархан сумын 14 дүгээр баг, 2 дугаар хороолол (амины орон сууцны нутаг дэвсгэр)	181.37 м <sup>2</sup>	20,909,746.55 (хорин сая есөн зуун есөн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин таван мөнгө)	43,900,000.00 (дөчин гурван сая есөн зуун мянган төгрөг)